

5. Хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах

ЗОРИЛГО

Хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглан төрийн инновацийг хөгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж, төрийн үйл ажиллагааг хялбар, хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, хүндрэл чирэгдэлгүй байх боломжийг бүрдүүлэх.

2,590
сая
төгрөг

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 7.3.17-д “Инновацад суурилсан техник, технологийн шинэчлэлийг сайжруулж, кибер гэмт хэргээс хамааралтай цахим нотлох баримтыг бэхжүүлэх, үнэлэх, хиймэл оюун ухааныг ашиглах чадамжийг хөгжүүлж, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.”

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.6-д “Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.”